

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ДЭЛГЭРХАНГАЙ СУМЫН НУТАГТ  
ОРШИХ “МАК ЦЕМЕНТ” ХХК-ИЙН ШИРЭЭГИЙН ХӨНДИЙ  
ГӨЛТГӨНИЙ УУРХАЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН  
ТАЙЛАН**

АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-016898  
АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5830974

**ТАНИЛЦСАН:**

БОАЖЯ-НЫ ХБОБНУГ-ЫН ДАРГА

/...../

**ХЯНАСАН:**

БОАЖЯ-НЫ ХБОБНУГ-ЫН

МЭРГЭЖИЛТЭН

/...../

**БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:**

“МАК ЦЕМЕНТ” ХХК-ИЙН  
УУРХАЙН ДАРГА

“МАК ЦЕМЕНТ” ХХК-ИЙН  
БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЭРГЭЖИЛТЭН



В. БАТТУЛГА

Г. ХАНДСҮРЭН

2022 он

## ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	13
3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ.....	15
4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	16
5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	24
6. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	25
7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	27
8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	28
9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	29
10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	32
11. ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ.....	37
12. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	50
13. ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	55
14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ГАРСАН НИЙТ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ.....	56
15. ДҮГНЭЛТ.....	57
16. ХАВСРАЛТ.....	58

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Компанийн танилцуулга:** “Монголын Алт” (МАК) ХХК нь 1993 онд үүсгэн байгуулагдсан, үндэсний хөрөнгө оруулалттай, Монгол улсын тэргүүлэх компаниудын нэг юм. Манай компани уул уурхай, барилгын материалын үйлдвэр, хөдөө аж ахуй, агаарын тээвэр, үл хөдлөх хөрөнгө, хэвлэл мэдээлэл зэрэг чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Үйл ажиллагааныхаа туршид улс, орон нутгийн төсөвт татвар төлөлтөөрөө тогтмол тэргүүлж ирсэн бөгөөд байгаль орчинд сөрөг нөлөө багатай, дэлхийд тэргүүлэх сүүлийн үеийн дэвшилтэт техник технологийг үйл ажиллагаа, үйлдвэрлэлдээ нэвтрүүлж, улс эх орныхоо хөгжил, эдийн засагт даацтай хувь нэмэр оруулах томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхлээд байна.

“Монголын Алт” (МАК) ХХК-ийн Хөх цав цемент-шохойн үйлдвэрийн төсөл болон үйлдвэрийн түүхий эдийг олборлох уурхайнуудын үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлэхээр 2014 оны 04-р сарын 16-нд МАК Цемент ХХК байгуулагдсан бөгөөд Ширээгийн хөндийн гөлтгөнийн уурхайн үйл ажиллагааг хариуцдаг.

### **Компанийн байгаль орчны бодлого:**

**Бидний эрхэм зорилго:** Компанийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн бүхий л үе шатанд байгаль орчинд үүсч болох аливаа сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, нөлөөллийг хамгийн бага байлгах талаар анхааран ажиллах нь компанийн нийт ажиллагсадын нэн тэргүүний зорилт болно.

**Бидний дээдлэх үнэт зүйлс:** Компани ба түүний салбар нэгжүүд нь үйлдвэр, уурхайн төслийг боловсруулах шатнаас үйл ажиллагааныхаа бүх хүрээнд байгаль орчны асуудлыг байнга анхаарч Монгол улсын байгаль орчны хууль, дүрэм, журам болон олон улсын хэмжээнд мөрдөж буй уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой гэрээ хэлэлцээрийг дагаж мөрдөнө. Эх орон, төрсөн нутаг, усаа хайрлан хамгаалах нь компанийн бүх ажилчид албан хаагчдын үнэт зүйл билээ.

**Баримтлах бодлого:** Манай компани нь дараах зорилтуудыг дэвшүүлж ажилладаг.

Үүнд:

- Байгалийн нөөц баялгийг урт удаан хугацаанд тогтвортой, үр ашигтай зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар баримталж ирсэн төрийн бодлогыг хэрэгжүүлж, эрх бүхий байгууллагаас баталсан байгаль орчны стандарт, хэм хэмжээ, дүрэм журмыг чанд сахин биелүүлж, дотоодын болон хөндлөнгийн байгаль орчны хяналтыг тогтмол гүйцэтгэх;
- Улсын болон орон нутгийн хэмжээнд тогтвортой үйл ажиллагаа явуулдаг байгаль орчныг хамгаалах чиглэлийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах;
- Олон улсын байгаль орчны байгууллагууд болон байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи бүхий туршлагатай компаниудтай хамтран ажиллаж, улмаар олон улсын байгаль орчны стандартуудыг өөрийн үйлдвэрлэл, үйл ажиллагаанд нэвтрүүлэх;

- Нөхөн сэргээгдэхгүй байгалийн нөөц баялгийг ариг гамтай, хаягдалгүй технологи болон дахин боловсруулах аргаар ашиглах;
- Байгалийн нөөцийн ашиглалтын үр ашгийг өндөр түвшинд байлгах зорилгоор тогтмол судалгаа шинжилгээг явуулж орчин үеийн үр ашигтай техник, технологийг үйлдвэрлэлдээ тууштай нэвтрүүлэх;
- Үйлдвэрлэл, уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн иргэдийн соёл, өв уламжлалыг хүндэтгэн хамгаалах, тэдний биет өв, ёс заншлын талаархи мэдээлэл, тэдгээрийн ач холбогдлыг компанийн ажилчдад тогтмол таниулах;
- Өөрийн компанийн байгаль орчны талаар баримтлах бодлого зарчмыг хамтран ажиллаж буй түнш, гэрээт гүйцэтгэгч нарт зааж таниулах, тавих шаардлагыг өндөржүүлэх замаар байгаль орчны чиглэлээр тэдний хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх;


**Төслийн нэр:** Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших MV-016898 тоот ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 166.25 га талбайд үйл ажиллагаа явуулж буй Ширээгийн хөндий нэртэй Гөлтгөнийн ордыг ашиглах юм.

**Төслийн зорилго:** Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших Ширээгийн хөндий нэртэй гөлтгөнийн ордыг эдийн засгийн үр ашигтайгаар ашиглах, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, дүрэм журам, стандартын дагуу үйл ажиллагаа явуулж, улс, орон нутгийн татварт төлбөрүүдийг төлөх, ордын хүрээлэн буй талбайн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх, шинээр ажлын байр бий болгох, ордын үр ашгийг улс, орон нутаг болон төсөл хэрэгжүүлэгч компанид хүртээхэд уг уурхайн зорилго оршиж байна.

#### **Төслийг хэрэгжүүлэгч:**

Нэр: МАК Цемент ХХК  
Улсын бүртгэлийн дугаар: 9011478063  
Регистрийн дугаар: 5830974  
Уурхайн удирдлага: Б.Баттулга  
Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 19-р хорр, “Монголын Алт”(МАК) ХХК өөрийн байр  
Цахим хуудас: [www.mak.mn](http://www.mak.mn)  
Холбогдох утас: 75759700, 98280992

**Төслийн байршил:** Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших MV-016898 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Ширээгийн хөндий нэртэй гөлтгөнийн орд нь Улаанбаатар хотоос 400 орчим км, Өмнөговь аймгийн төв Даланзадгадыг холбосон шороон замаас зүүн тийш 9 км орчим зайд оршино. Дэлгэрхангай сумын төвөөс баруун урагш 50 км, Говьсүмбэр аймгийн төв Чойр хотоос 400 км зайтай. Засаг захиргааны хувьд Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт оршино.



Зураг 1. Уурхайн байршил

Хүснэгт 1. Уурхайн талбайн солбицолын цэгүүд

№	Уртраг			Өргөрөг		
	Град	Мин	Сек	Град	Мин	Сек
1	104	16	38	45	2	25
2	104	16	0.99	45	2	25
3	104	16	0.99	45	2	31.55
4	104	16	38	45	2	31.55

**Хүчин чадал:** Жилд 107-110 мян.тн орчим гөлтгөнө олборлох ба үүнээс 100 мян.тн-ыг Дорноговь аймгийн Даланжаргалан суманд орших “Хөх цавын цемент-шохойн” үйлдвэрт, 7-

10 тн-ыг Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт орших хийт бетоны үйлдвэрт нийлүүлнэ. Уурхайн ашиглалтын хугацаа 13 жил. Уурхайн эцсийн гүн 5-7м.

### Ордын уул-техникийн нөхцөл

Ширээгийн хөндийн гөлтгөний орд нь гөлтгөнө агуулсан хурдасын хэвтээ зузаан 2-7м, 100-400 м өргөн, уртаараа 1800 м хүртэл байна. Хөрс 0.0-3.3 м хүртэл зузаантай элсэн чулуу, шавартай холилдсон уулын хайрга чулуунаас бүрдэнэ. Ордын гидрогеологийн нөхцөл байдал нь хуурай, хөрсний болон гүний усны ямар нэгэн илрэл байхгүй учир гидрогеологийн ямар нэгэн хүндрэл үүсэхгүй. Ашигт малтмалын биетийн байршил, ордын уул-геологийн нөхцөл нь хүдрийг ил аргаар олборлох таатай нөхцөлийг бүрдүүлнэ. Ордын хуулах хөрсний зузаан, нөөцийн харьцаа нөөц тооцсон хэсэгт 1:2.18 орчим байна.

### Уурхайн жилийн хүчин чадал

Гөлтгөний уурхай нь 2022 онд 52,710 мян.тн (35877 м<sup>3</sup>, эзэлхүүн жин 2.3 тн/м<sup>3</sup>-тооцов ) гөлтгөнө бэлтгэн ажилласан. Үүний дагуу уурхайн 2022 оны төлөвлөлтөнд 111.54 мян.тн (ТЭЗҮ-д заасны дагуу агуулгаа 35.51%-р тооцов, сийрэгжилтийн коэффициент 1.2) гөлтгөнөтэй хурдас олборлож, 58,125 мян/м<sup>3</sup> хөрс хуулалт хийгдсэн. Гөлтгөнөтэй хурдас ангилан ялгах бутлуураас гарсан 58,382 мян/м<sup>3</sup> хаягдал шаврыг дотоод овоолгод буулгасан. 2022 онд уулын ажлыг 2 дүгээр сарын 15-наас 06 дугаар сар хүртэл 5 сарын сарын турш уулын ажил явагдсан.

### Уурхайн ажиллах горим

2022 онд дараах ажлын горимоор ажилласан.

Хүснэгт 2. Уурхайн ажиллах горим

№	Үзүүлэлт	Хугацаа
1	2022 онд ажилласан хоног	140 хоног
2	Сард ажиллах хоногийн тоо	25
3	Хоногт ажиллах ээлжийн тоо	2
4	Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	12 цаг
5	Цайны цаг	60 мин
6	Ээлж солилцох, тосолгоо хийх	60 мин

### Уурхайн талбайд ашиглалт явуулах дараалал

Орд хэвтээ уналттай ба ашигт зузаалгын хэмжээ бага байгаатай уялдан уурхай нь 7.5м хүртэл гүнтэйгээр үүсгэх ба ашиглалтын дарааллын хувьд хайгуулын шугам II-II<sup>I</sup>-оос хайгуулын шугам I-I<sup>I</sup> хүртэл уулын ажлын чиглэл нь урдаас хойшоо 1190м-ын түвшин хүртэл гүнзгийрч, хойшоо 82 м ахилтгайгаар уулын ажлыг явуулсан.

Уурхай нь ашиглалтын жилд дотоод овоолго үүсгэх байдлаар техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийхээр ТЭЗҮ-д тусгагдсан.

Хүснэгт 3. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

Үзүүлэлт	хэмжих нэгж	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	Нийт
Сард ажилласан хоног	Хоног	22	22	21	22	23	196
Сард бүтээлтэй ажиллах хоног	Хоног					10	120
Календар цаг	Цаг	528	528	504	528	552	4704
Сарын цаг ашиглалт		1	1	1	1	1	1
Цаг ашиглалт	%	0.75	0.75	0.75	0.75	0.75	0.75
Сард ажиллах үндсэн цаг	Цаг	484	484	462	484	506	4312
Цэвэр ажилласан цаг	Цаг	396	396	378	396	414	3528
Цементийн үйлдвэр	тн/сар	6,059	6,059	6,429	6,735	7,041	31,840
Хийт бетоны үйлдвэр	тн/сар	208.65	208.65	208.65	785.71	821.43	2,170
Нийт	тн/сар	7,520	7,520	7,179	7,520	7,862	46,871

### Хөрс хуулах, гөлтгөнөтэй хурдас олборлолтын ажил

Ширээгийн хөндий гөлтгөний уурхайн хөрс нь 0.0-3.3 м хүртэл зузаантай элсэн чулуу, шавартай холилдсон уулын хайрга чулуунаас бүрддэг тул өрөмдлөг тэсэлгээ хийхгүй шууд ухаж ачих боломжтой юм.

Уурхайн хүчин чадал бага, жилд хийх газар шорооны ажлын хэмжээ уулын цулаар 275.5 мян/м<sup>3</sup>-с хэтрэхгүй тул авто тээвэртэй ашиглалтын системээр ажилласан. Үүнд:

- ✓ Экскаватор: 1.19 м<sup>3</sup>-ийн багтаамжтай шанагатай CAT323D 1 ширхэг
- ✓ Автосамосвал: 25 тн-ийн даацтай Норд-бенз автосамосвал 3 ширхэг хослолоор ажиллахаар тооцсон.
- ✓ Утгуур ачигч: 6 м<sup>3</sup>-ийн багтаамжтай шанагатай CAT980G 1 ширхэг




Зураг 2. Уурхайн өнөөгийн байдал



### Уурхайн техник тоног төхөөрөмж:

Хүснэгт 4. CAT-323D экскаваторын техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Утга
1	Тээвэрлэлтийн үеийн өндөр	мм	3250
2	Тээвэрлэлтийн үеийн урт	мм	9050
3	Арын эргэлтийн радиус	мм	2750
4	Чиглүүлэгч болон одон дугуйн төв хоорондын зай	мм	3650
5	Явах ангийн урт	мм	4455
6	Газрын гадаргаас доод их бие хүртлэх зай	мм	450
7	Явах ангийн төв хоорондын зай	мм	2380
8	Явах ангийн өргөн	мм	3180
9	Кабины орой хүртлэх өндөр	мм	2950
10	Газрын гадаргаас арын их бие хүртлэх зай	мм	1020
11	Сумны сонголт	м	5.2 (mass boom)
12	Гарны сонголт	-	M2.4CB2
13	Жин	тн	23.1



Хүснэгт 5. HOWO-371 маркийн 54 тн-ын даацтай автосамосвал


Тээврийн төрөл	Тээвэрлэх зай		
	Хамгийн хол	Хамгийн ойр	Дундаж
Гэлтгөнтэй хурдас-г уриншийн талбайд	1.5 км	0.8 км	1 км (1 талдаа)
Уриншсан гэлтгөнөтэй хурдасыг уриншийн овоолгод	800 м	500м	650 м (1 талдаа)
Бутлуур, шигшүүрийн хаягдлыг дотоод овоолгод	600м		600м (1 талдаа)
Хөрс тээвэр (дотоод овоолго)	800м		800м (1 талдаа)



Нowo-371 маркийн 54 тн-ын даацтай автосамосвал нь САТ-323D экскаватортой хослон ажиллаж нийт 165.3 мян/м<sup>3</sup> хөрсийг 0.8 км хүртэл зайд хөрсний дотоод овоолго хүртэл, 110.2 мян/м<sup>3</sup> гөлтгөнөтэй хурдасыг 1 км хүртэл зайд уриншуулах талбай хүртэл гөлтгөнөтэй хурдас тээвэрлэлт хийхээр тооцсон.

Хүснэгт 6. САТ-980 маркийн ачигчийн техникийн үзүүлэлтүүд

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Утга
1	Кабины орой хүртлэх өндөр	мм	3714
2	Кабины орой дээрх маяк хүртлэх өндөр	мм	3776
3	Дугуйн тэнхлэгийн гол хүртлэх өндөр	мм	855
4	Газрын гадаргаас доод их бие хүртлэх зай	мм	430
5	Шанагаа буулгасан үеийн нийт урт (тээвэрлэлтийн үеийн)	мм	9456
6	Хойд дугуйн тэнхлэгийн голоос арын буфер хоорондын урт	мм	2615
7	Дунд талын нугасан холбоосноос урд дугуйн тэнхлэгийн гол хүртлэх урт	мм	1850
8	Урд, хойд дугуйнуудын тэнхлэгийн гол хоорондын урт	мм	3700
9	Шанаганы 45 <sup>0</sup> -ын байрлал дахь өндөр	мм	2828
10	Ачилтын өндөр	мм	3670
11	Шанаганы улыг тэгш өргөсөн үеийн өндөр	мм	3580
12	Шанагаа өргөсөн үед шанаганы түлк хүртлэх өндөр	мм	3907
13	Шанагаа өргөсөн үеийн нийт өндөр	мм	5147
14	Шанаганы 45 <sup>0</sup> -ын байрлал дахь шанаганы үзүүрээс урд дугуй хүртлэх зай	мм	1064
16	Ухах гүн	мм	100
17	Шанаганы өргөн	мм	3400
18	Дугуйн төв хоорондын өргөн	мм	2762
19	Эргэлтийн радиус (шанаганы гадна талаар авсан хэмжээгээр)	мм	7960
20	Дугуйнуудын гадна талаар авсан өргөн	мм	3250
23	Дүүрэн ачаатай, бүрэн өргөсөн үеийн шанаганы өнцөг	градус	61
24	Асгах үеийн шанаганы өнцөг	градус	47
25	Тээвэрлэлтийн үеийн шанаганы өнцөг	градус	45
26	Явах ангийн хойд хэсгийн буфер хоорондын өнцөг	градус	33
27	Урд, хойд тэнхлэгийн хоорондын нугасны эргэлтийн өнцөг	градус	40
28	Сумны сонголт	-	Standart lift
29	Жин	тн	29.9




Хүснэгт 7. Бутлуур шигшүүрийн тоног төхөөрөмж

№	Нэр	Марк	Хүчин чадал	Тоо.ш	Суурь чадал, кВт	Нийт чадал, кВт	Жин, тн
1	Чичиргээт гэжээгүүр	ZSW380*96	Q=90-200 тн/цаг	1	11	11	3.98
2	Хацарт бутлуур	PE500*750	Q=80-150 тн/цаг	1	55	55	9.6
3	Чичиргээт шигшүүр	2YA1860	Q=50-350 тн/цаг	1	18.5	18.5	5.6
4	Хянах самбар			1	100.0	100	1.2
5	Туузан конвейер	B800	Хурд 1-2 м/сек Q=276-546 тн/цаг Урт – 35 м	1	18.5	18.5	3.6
6	Туузан конвейер	B500	Хурд 0.8-2 м/сек Q=78-191тн/цаг Урт – 15 м	3	5.5	16.5	8.1
<b>Нийт</b>				<b>8</b>	<b>208.50</b>	<b>219.50</b>	<b>32.08</b>



Зураг 3. Техник тоног төхөөрөмж

**Усан хангамж:** Төслийн талбай нь Төв Азийн гадагш урсгалгүй ай сав, Онги-Таац голын сав газрын түр урсгал бүхий гол горхитой мужид хамаарна. Тухайн бүс нутагт гадаргын усны сүлжээ маш сийрэг бөгөөд үндсэндээ байнгын урсацтай гол горхи байхгүй юм.



Зураг 4. Төслийн талбайн гадаргын усны сүлжээ

Одоогоор унд ахуйн хэрэглээний усаа Онги голын хөндийд орших малчны худгаас зөөвөрлөн авч хэрэглэж байна. 2016 онд Ширээгийн хөндийд 0.1-0.2л/с ундаргатай гүний худаг гаргасан боловч уг худгийн ус лабораторийн шинжилгээгээр унд ахуйд тохиромжгүй гэж гарсан тул ногоон байгууламжийн усалгаанд ашиглаж байна.

**Цахилгаан хангамж:** Ширээгийн хөндийн гөлтгөний ил уурхайд засварын цех, уурхайчдын хотхон болон бутлах үйлдвэрийн хэрэглэгчид нь 0.4кВ болон 6кВ-ын цахилгаан эрчим хүчээр хангагдах шаардлагатай. Сайхан-Овоогоос Мандал-Овоо хүртэлх 15кВ-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам нь Ширээгийн хөндийн гөлтгөний ил уурхайгаас урагш 8 км зайтай бөгөөд тэндээс цахилгаан дамжуулах агаарын шугамыг татаж авсан.



Зураг 5. Уурхайн дэд станц

**Завсрын болон эцсийн бүтээгдэхүүн:** Төслөөс завсрын бүтээгдэхүүн гарахгүй. Харин эцсийн бүтээгдэхүүн нь гөлтгөнө юм. Байгаль дээр гөлтгөний чулуу нь голдуу цагаан өнгөтэй тохиолддог тунамал гаралтай чулуулаг. Байгалийн гөлтгөний чулууны найрлагад шавар, элс, шохойн чулуу болон органик хольц орсон байдаг. Цэврээрээ байгаа гөлтгөнө  $\text{CaSO}_4 \cdot \text{H}_2\text{O}$  гэсэн химийн томъёотой ба түүний найрлагад 32.56% кальцийн исэл, 46.51% - ийн хүхрийн ангидрит, 20.93%-ийн ус агуулагдана. Манай орны гөлтгөнийн чулуулгийн орд газрын дийлэнх нь шаварлаг хольц ихтэй саарлаас бор, улаавтар чулуулагтай байдаг. Шаварлаг хольцын хэмжээ нь заримдаа 30-60% -д хүрдэг.


Тус ордын гөлтгөнө нь цемент үйлдвэрлэхэд барьцалдах хугацаа тохируулах зорилгоор ашиглах стандартын шаардлагыг бүрэн хангаж байгааг Хөтөлийн цементийн үйлдвэрт хийсэн хагас үйлдвэрлэлийн туршилтын үр дүнд тодорхойлсон байна.

**Ил уурхайн ашиглалтын технологи:** Ордын уул техникийн нөхцөл, гөлтгөнө агуулсан хурдаст давхаргын тогтоц, хөрсний зузаан зэргийг харгалзан үзэж авто тээвэртэй, дотоод овоолго бүхий технологиор ашиглахаар ТЭЗҮ-д тусгаж батлуулсан байна.

**Шимт хөрсний овоолго:** Уурхайн ашиглалтын явцад үйл ажиллагаанд өртөх уурхайн талбайн хэсэг хөрсний овоолгыг 0.1-0.35м зузаантай буюу элс, элсэнцэр зэрэг ургамал ургах боломжтой шимэрхэг хөрс, бусад тохиромжтой хөрсийг 0.3м хүртэл зузаантайгаар урьдчилан хуулж бэлдсэн. Шимт хөрсний овоолгын өндөр нь 4м байх бөгөөд хажуугийн өнцөг нь 25-30 градус байна.

**Гөлтгөнө буталж, ангилах хэсэг:** Ширээгийн хөндийн гөлтгөнийг олборлон хуурай аргаар буталж, 2-3м нуруулдан овоолж, сэврээн хатааж 1 жил уриншуулаад, ангилан ялгаж технологийн схемийн дагуу чичиргээт тэжээгүүрт тэжээн, хацарт бутлуураар бутлах ба бутлагдсан гөлтгөнийг 50-150мм, 25-50мм-ийн 2 төрлийн шигшүүрээр шигшиж, цемент болон хийт бетоны үйлдвэр рүү нийлүүлнэ. Харин 0-25мм ширхэглэлтэй хурдас буюу хаягдлыг уурхайн дотоод овоолго руу шилжүүлнэ.


**Гөлтгөнө гаргалт:** Уурхайн нийт ашиглалтын 13 жилийн хугацаанд бутлан ангилах цехээс 35.51% -ийн гарцтай 1.4 сая.тн гөлтгөнийг гаргахаар төлөвлөсөн.



Зураг 6. Бутлуур, шигшүүрийн ажлын зураг



Зураг 7. Бутлуур, шигшүүрийн тоног төхөөрөмж



Зураг 8. Шигшүүрийн ажлын зарчмын схемийн бүдүүвч зураг

Бутлан, ангилах технологид ус шаардагдахгүй бөгөөд гөлтгөнийн-конкреци нь чийг багатай тул гөлтгөнөтэй хурдсыг уулаас олборлосны дараа буталж, ердийн агаарын температурт 1 жил хатаан уриншуулна. Уриншсан гөлтгөнөтэй хурдсыг хацарт бутлуурт буталж, бутлагдсан гөлтгөнөтэй хурдсыг шигшүүрээр ангилан ялгана.

## 2. УУРХАЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Гөлтгөний ордоос гөлтгөнө олборлох, боловсруулах, тээвэрлэх төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг 2021 онд шинэчлэн боловсруулсан төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тодорхойлсон байдаг. Төсөл хэрэгжиж байгаа бүс нутагт Мак Цемент ХХК-аас гадна “Эрдэнэгибс” ХК зэрэг аж ахуйн нэгжүүд гөлтгөний уурхайн төсөл хэрэгжүүлдэг учраас тухайн газрын хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөлөл нь хам шинж чанартай юм.

Гөлтгөний ордоос гөлтгөнө олборлох, боловсруулах, тээвэрлэх төслийн үйл ажиллагаанаас үүсэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг түүнд өртөх орчноор нь буюу агаар, гадаргын болон газар доорх ус, хөрс, амьтан ургамлын аймгийг хамруулан дараах байдлаар тодорхойлсон.

### **Агаарын чанарт үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд:**

#### **Гол сөрөг нөлөөллүүд:**

- Уурхайн хөрс хуулалт, гэлтгөнө олборлолт, ачиж буулгах үйл ажиллагаа болон хөдөлгөөнт эх үүсвэрээс агаарт PM10-аас жижиг хэмжээтэй нарийн ширхэгт тоосонцорын хэмжээ ихсэх.
- Элэгдэл эвдрэлд өртсөн газраас салхины болон хөдөлгөөнт техникийн нөлөөгөөр тоосжилт үүсэх.
- Уурхайд ажиллаж байгаа техник, тоног төхөөрөмжөөс үүсэх дуу шуугиан.
- Хүнд даацын машин болон бусад техникээс бохирдуулагч хий агаарт ялгарах

#### **Болзошгүй сөрөг нөлөөллүүд:**

- Төслийн хэмжээнд ашиглаж байгаа зам эвдрэх, зам засах зэргээс шалтгаалан шороон зам гарган ашигласнаас агаарт тоосжилт үүсэх.

### **Усны чанарт үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд:**

- Хайгуулын ажил болон гидрогеологийн хайгуулын ажлын явцад гүний ус илрээгүй. Иймд ордын олборлолтын явцад ус шүүрүүлэх ажил явагдахгүй.
- Төслийн талбай орчимд байнгын урсацтай гол горхи байхгүй тул гадаргын усанд үзүүлэх нөлөөлөл үүсэхгүй.

### **Хөрсний чанарт үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд:**

#### **Гол сөрөг нөлөөллүүд:**

- Олборлолт явуулах талбайн шимт хөрсийг хуулж овоолго үүсгэснээр тухайн газрын хэлбэр төрхөд өөрчлөлт орох.
- Шинээр барилга байгууламж барих, зам гаргах зэргээс хөрсөн бүрхэвч эвдрэл элэгдэлд орох.

#### **Болзошгүй сөрөг нөлөөллүүд:**

- Салаа зам үүсгэснээс шалгаалан хөрс эдэгдэл эвдрэлд орох
- Тос, тосолгооны материал, бохир ус асгарсанаас шалтгаалан хөрс бохирдох
- Хуурай хог хаягдлыг зөвшөөрөлгүй газар хаяснаар хөрс бохирдох
- Борооны усны угаагдал, үерийн усны улмаас бохирдол зөөгдөн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах

### **Ургамлан нөмрөг ба амьтны аймагт үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд:**

#### **Гол сөрөг нөлөөллүүд:**

- Олборлолт явуулах талбайн шимт хөрсийг хуулж овоолго үүсгэснээр тухайн газрын ургамлан бүрхэвч устах.
- Шинээр барилга байгууламж барих, зам гаргах зэргээс хөрсөн бүрхэвч эвдрэл элэгдэлд орж тухайн хэсгийн ургамлан бүрхэвч доройтох
- Уул уурхай түүнийг дагасан үйлдвэр, суурьшлаас тухайн бүс нутгийн амьтан дайжих,

дүрвэх

- Уурхайн хөрс хуулалт, хашаажуулалт зэргээс амьтны амьдрах орчин, идэш тэжээл хязгаарлагдах.

#### **Болзошгүй сөрөг нөлөөллүүд:**

- Салаа зам үүсгэснээс шалгаалан хөрс элэгдэл эвдрэлд орж ургамлан бүрхэвчид нөлөөлөх.
- Төслийн үйл ажиллагааны улмаас үүсэх тоосжилт ургамлын гадаргууд бууснаар фотосинтезийн процессийг багасгаж ургамлын ургалтанд нөлөөлөх
- Тээврийн зам хөндлөн гарах амьтад машинд дайруулах

### **3. ГӨЛТГӨНИЙ УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ҮНДСЭН ҮР ДҮН**

Дундговь аймгийн Дэлгэрхангай суманд орших Ширээгийн хандийн Гөлтгөний уурхайн Байгаль орчны менежмент төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулахдаа БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А-618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежмент төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримталсан бөгөөд тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын биелэлтийн байдлыг нэг бүрчлэн тодорхойлж, шаардагдсан хөрөнгө зардлыг тооцсон бөгөөд орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийн хэсэгт хяналт шинжилгээний ажлын үр дүнг дэлгэрэнгүй хэлбэрээр тусгасан болно. Гөлтгөний уурхайн үйл ажиллагаа 2022 оны 2-р сараас 6 сарын хооронд ажилласан.

2022 оны Гөлтгөний уурхайн Байгаль орчны менежмент төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлсэн гол үйл ажиллагаанууд, түүний үр дүнг дурдвал.

- Уурхайн дотоод овоолгийн 0.5 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж, 0.3 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн.
- Уурхайн хотхоны гадна талбайд 100 ширхэг мод сөөг тарьсан.
- Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Дэлгэрхангай сумын төвийн цэцэрлэг хүрээлэнд мод тариж усалгаа арчилгааг хийж гүйцэтгэсэн.
- Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд үйлдвэр, уурхайн хэмжээнд бэлтгэл ажлыг хийж мод үржүүлэг байгуулан тарилтын ажлыг хийж гүйцэтгэсэн.
- Гөлтгөний уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй болзошгүй ба гол сөрөг нөлөөллийг хянах зорилгоор агаарын чанар, газар доорх ус, хөрсөн бүрхэвч зэрэг чиглэлээр орчны хяналт шинжилгээний ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд түүний биелэлтийн тоон үзүүлэлтийг дараах хүснэгтэнд нэгтгэн илэрхийлэв.



Хүснэгт 8. Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын хэрэгжилт

д/д	Байгаль орчны хамгаалах арга хэмжээний төрөл	Төлөвлөсөн ажлын тоо	Гүйцэтгэсэн ажлын тоо	Хийгдэж буй болон хойшлогдсон ажлын тоо
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	11	11	-
2	Нөхөн сэргээлт	2	2	-
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	1	1	-
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-	-	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-	-	-
6	Хог хаягдлын менежмент	5	5	-
7	Осол эрсдлийн менежмент	5	5	-
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	11	11	-
9	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	7	7	-
10	Олон нийтэд тайлагнах үйл ажиллагаа	3	3	-
	<b>Нийт</b>	<b>45</b>	<b>45</b>	<b>-</b>

#### 4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

##### 4.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөлийг бууруулах чиглэлээр

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	Хүнд машин механизмаас тоосжилт үүсэх	Уурхайн дотоод тээврийн зам талбай	Дотоод замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор хурдны хязгаарт хяналт тавин, тэмдэг зааврыг мөрдөж ажилласан.	100,0	Тухай бүрт
2		Гадаад тээврийн зам	Гадаад тээврийн машин механизмын хурдны хязгаар 40км/ц-аас хэтрэхгүй байхаар хязгаарлах зааварчилгаа өгч, тэмдэг, тэмдэглэгээ байрлуулан, засаж сайжруулсан.	500,0	Жилийн турш
3	Бүтээгдэхүүн тээвэрлэх явцад тоосжилт, бохирдол үүсэх	Гэлтгөнө тээврийн машин	Тээврийн машины бүтээлгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавиж ажилласан.	50,0	Тухай бүрт

4	Агаар мандалд тоосжилт үүсэх	Уурхайн ажилчдын хотхон	Уурхайн ажилчдын хотхонд 100 ширхэг мод шинээр тарьж ургуулсан.	Үйл ажиллагааны зардлаас	6 дугаар сарын 1-нээс өмнө
<b>Нийт зардал мян.төг</b>				<b>650,000</b>	

#### 4.1.1 Тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарлах тэмдэг зааврыг мөрдөж ажиллах

Уурхайн дотоод замын тэмдэг, тэмдэглэгээг сайжруулсан бөгөөд хурдны хязгаарлалтыг даган мөрдүүлж ажиллаж байна.



Зураг 9. Уурхайн дотоод замын тэмдэгүүдийн харагдах байдал

#### 4.1.2 Гадаад тээврийн машин механизмын хурдны хязгаарт хяналт тавьж, тэмдэг тэмдэглэгээг сайжруулах

Гадаад тээврийн машин механизмын хурдны хязгаарт хяналт тавьж ажилласан бөгөөд тэмдэг тэмдэглэгээг сайжруулсан.



Зураг 10. Гадаад тээврийн замд тэмдэг байршуулж буй байдал

#### 4.1.3 Тээврийн машины бүтээлгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих

“Конкорд бридж” ХХК нь Ширээгийн хөндий гөлтгөний уурхайгаас тээвэрлэлтийн үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэдэг бөгөөд гөлтгөнө тээвэрлэх явцад зориулалтын хучлага хэрэглэн, тээвэрлэлтийн үйл ажиллагааг гүйцэтгэж байна.



Зураг 11. Гөлтгөнө тээврийн машинууд хучилтаараа бүрэн бүтээж тээвэрлэлт хийж буй байдал.

#### 4.1.4 Мод сөөг шинээр тарьж ургуулах

2022.05.25-ны өдөр 50 ш улиас, 50 ш бургас нэмж тарьсан. Нийт уурхайн хотхоны хэмжээнд 8 төрлийн 673 ширхэг мод, сөөг ургаж байна.



Зураг 12. Хаврын тарилт хийж буй байдал

Хүснэгт 9. Тарилт хийсэн модны төрөл зүйл

Дд	Мод сөөгний нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Өндөр \см	Мод авсан газар
1	Улиас / <i>Populus Ifolia</i> /	ширхэг	50	130-170	Төгөл ХХК
2	Бургас/ <i>Salix pentandra</i> /	ширхэг	50	130-160	
	<b>Нийт дүн</b>		<b>100</b>		

#### 4.2 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөлийг бууруулах чиглэлээр

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	Унд ахуй болон мод бут, ногоон байгууламжинд ашиглаж буй зөөврийн усыг бүртгэж, зохистой хэрэглээнд хяналт тавих	Уурхайн хэмжээнд	Унд ахуйн усыг уурхайгаас баруун тийш 10 орчим км зайд байрлах малчны гар худгаас авдаг ба LAND 78 маркийн машинаар, мод бут, ногоон байгууламжид ашиглаж байгаа усыг уурхайн уснаас Норд Бенз маркийн машинаар зөөвөрлөдөг ба “Зөөврийн цэвэр усны бүртгэл”-ийг бүртгэдэг.	Үйл ажиллагааны зардлаас	Тухайн Жилдээ
Нийт зардал мян.төг				-	

##### 4.2.1 Унд ахуй болон мод бут, ногоон байгууламжинд ашиглаж буй зөөврийн усыг бүртгэж, зохистой хэрэглээнд хяналт тавих

Унд ахуйн усыг уурхайгаас баруун тийш 10 орчим км зайд байрлах малчны гар худгаас авдаг ба LAND 78 маркийн машинаар, мод бут, ногоон байгууламжид ашиглаж байгаа усыг уурхайн уснаас Норд Бенз маркийн машинаар зөөвөрлөдөг ба "Зөөврийн цэвэр усны бүртгэл"-ийг бүртгэдэг. Уурхайн 2-р сараас 6-р сарын 1-ны хүртэл нийт 5 сар ажилласан бөгөөд ажиллах хугацаандаа унд ахуйн болон ногоон байгууламжид ашиглаж буй усны бүртгэлийг тогтмол бүртгэсэн. (Хавсралт 1. Усны бүртгэлийг [ЭНД](#) харна уу)




График 1. Усны зарцуулалт (сараар, м³)

Тайлбар: 2022 оны ус ашиглах дүгнэлтээр унд ахуйн хэрэгцээнд 300 м<sup>3</sup>/жил, ногоон байгууламжийн усалгаанд 1267,2 м<sup>3</sup>/ жил ус ашиглахаар гарсан бөгөөд бодит хэрэглээгээр унд ахуйд 100 м<sup>3</sup>/ жил, ногоон байгууламжид 125 м<sup>3</sup>/ жил усыг ашигласан байна. Усны төлбөрийг усны дүгнэлтээр буюу 1,052,812 төгрөгийг холбогдох дансанд шилжүүлсэн.




График 2. Усны дүгнэлтээр гарсан дүн болон 2022 оны усны зарцуулалттай харьцуулсан байдал

#### 4.2 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөлөлийг бүүрүүлэх чиглэлээр

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	Үржил шимт хөрсийг стандартын дагуу хуулж, хадгалах ба уг үйл ажиллагаанд хяналт тавих.	Уурхайн ахилтын талбай	МАК Цемент ХХК нь Монгол Улсын стандарт MNS 5916:2008 газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалтын дагуу 5 метрээс илүүгүй өндөртэй байгуулсан. Уул уурхай, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахаас өмнө хөрсний үе давхаргын зузааныг тодорхойлж, харилцан адилгүй тогтоосон гүн хүртэл шимт хөрсийг хуулж хадгалж, чанарын хяналт хийж гүйцэтгэв.	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүрт
2	ШТМ-ын алдагдаж болзошгүй газарт шаардагдах хэрэгсэл, материалыг бэлтгэх, бэлэн байлгах	Үйлчилгээний талбайд	Техникийн тосолгоо үйлчилгээ, угаалга зэргийг зориулалтын талбайд хийж байна.	150,000.0	Тухай бүрд

3	ШТМ-ын асгаралтад хяналт тавьж, бохирдсон хөрсийг бүртгэн, тусгай зориулалтын талбайд саармагжуулах	Төслийн талбайд	ШТМ-ын асгаралтанд хяналт тавьж, бохирдсон хөрсийг бүртгэн, тусгай зориулалтын талбайд саармагжуулж байна.	-	Ш улиралд зун
5	Газар хөндөх зөвшөөрөл авах, олгох, хяналт тавих	Үйлдвэрийн хэмжээнд	2021 оны 4 дүгээр сараас 8 дугаар сарын 01-ний хүртэлх хугацаанд нийт 2 удаа газар хөндөх зөвшөөрлийн хүсэлтийг хүлээн авч зөвшөөрлийг баталсан бөгөөд уурхайн нөлөөгөөр нийт 1.5 га талбайг хөндсөн. Уурхайн үйл ажиллагааны улмаас хөндөгдсөн талбайн бүртгэлийг тогтмол хийж байна..	50,000.0	Жилдээ
<b>Нийт зардал мян.төг</b>				<b>200,0</b>	

#### 4.3.1 Үржил шимт хөрсийг стандартын дагуу хуулж, хадгалах ба уг үйл ажиллагаанд хяналт тавих

Өнгөн хөрсийг хадгалж хамгаалах нь стратегийн өндөр ач холбогдолтой бөгөөд газар хөндөхөөс өмнөх үеийн ургамлан бүрхэвч болон биологийн төрөл зүйлийн амьдрах орчныг дахин бий болгох буюу нөхөн сэргээлтийг амжилттай хийхэд өнгөн хөрсний хадгалалт, хамгаалалт чухал юм. Говийн уур амьсгалын хатуу нөхцөлд ургамлын үр үрсэлж, үндэсний систем хөгжихөд тохирсон хөрсний нөөц нэн шаардлагатай байдаг. Иймээс МАК Цемент ХХК нь Монгол Улсын стандарт MNS 5916:2008 газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалтын дагуу 5 метрээс илүүгүй өндөртэй байгуулсан. Уул уурхай, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахаас өмнө хөрсний үе давхаргын зузааныг тодорхойлж, харилцан адилгүй тогтоосон гүн хүртэл шимт хөрсийг хуулж хадгалж, чанарын хяналтыг хийж байна.



Зураг 13. Шимт хөрсний овоолго

#### 4.3.2 ШТМ-ын алдагдаж болзошгүй газарт шаардагдах хэрэгсэл, материалыг бэлтгэх, бэлэн байлгах

Засвар үйлчилгээний төвд болон гадаах хатуу хучилттай зориулалтын талбайд техникийн тослогоо үйлчилгээ, угаалга зэргийг хийж байна.



Зураг 14. Техникийн тосолгоо үйлчилгээ, угаалгын зориулалтын талбай

#### 4.3.3 ШТМ-ын асгаралтад хяналт тавьж, бохирдсон хөрсийг бүртгэн, тусгай зориулалтын талбайд саармагжуулах

Техникийн урсгал засварууд болон тос масло солих үйлчилгээг Засвар үйлчилгээний төв болон зориулалтын хатуу хучилттай талбайд гүйцэтгэж байна. Тайлант онд төслийн талбайд нийт 4 удаагийн асгаралт үүссэн. Бохирдсон хөрсийг зориулалтын талбайд EM-1 бодисыг ашиглан саармагжуулсан. Уг бодис нь 80-100 төрөл зүйлийн ашигтай бичил биетэнг агуулдаг бөгөөд эдгээрээс дурдвал *Lactobacillus plantarum*, *Lactobacillus casei*, *Streptococcus*, *Saccharomyces cerevisiae*, *Candida utilis*, *Rhodospseudomonas palustris*, *Rhodobacter sphaeroides*, *Streptomyces cerevisiae*, *Streptomyces geiseus* зэрэг бактериуд агуулсан байдаг.




Зураг 15. Тосоор бохирдсон хөрсийг зориулалтын талбайд саармагжуулж буй байдал

#### 4.3.4 Газар хөндөх зөвшөөрөл авах, олгох, хяналт тавих

2022 оны 2 дугаар сараас 6 дугаар сар хүртэлх хугацаанд нийт 3 удаа газар хөндөх зөвшөөрлийн хүсэлтийг хүлээн авч зөвшөөрлийг баталсан бөгөөд уурхайн нөлөөгөөр нийт 5.74 га талбайг хөндсөн. Уурхайн үйл ажиллагааны улмаас хөндөгдсөн талбайн бүртгэлийг тогтмол хийж байна. (Хавсралт 2. Газар хөндөх зөвшөөрлийн хуудсыг [ЭНД](#) харна уу)

Хүснэгт 10. Газар хөндөлтийн нэгтгэл

№	Байршил	Зориулалт	Он сар өдөр	Талбайн хэмжээ /га/
1	Уурхайн карьер	Шимт хөрс хуулалт	2022.03.22	3.24
2	Уурхайн карьер	Өнгөн хөрс хуулалт	2022.04.03	0.3
3	Уриншийн талбай	Өнгөн хөрс хуулалт	2022.04.07	2.2
<b>Нийт</b>				<b>5.74</b>



Зураг 16. Шимт хөрсний хуулалт хийх төлөвлөлтийн зураг



#### 4.6 Ургамлан бүрхэвч, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөлийг бууруулах чиглэлээр

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	Мод тарьсан талбай, ногоон байгууламжийн усалгаа арчилгаа хийх	Төслийн талбайн хэмжээнд	Уурхайн ногоон байгууламжийн талбайд таригдсан мод, сөөгийг тогтмол услаж, биомассийг нэмэгдүүлж байна.	700,0	Тухайн жилдээ
<b>Нийт зардал мян. төг</b>				<b>700,0</b>	

##### 4.6.1 Мод тарьсан талбай, ногоон байгууламжийн усалгаа арчилгаа хийх



Зураг 17. Усалгаа арчилгаа болон биомасс үүссэн байдал

#### 5. НӨХӨН СЭРГЭЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	Нөхөн дүүргэлтээр техникийн нөхөн сэргээлт хийх	Дотоод овоолго	0.5 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн.	63,117,250	Жилийн турш
2	Биологийн нөхөн сэргээлт хийх		Техникийн нөхөн сэргээлт хийсэн 0.5 га талбайгаас 0.3 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийсэн.		
<b>Нийт зардал мян. төг</b>				<b>63,117,250</b>	

## 5.1 Нөхөн дүүргэлтээр техникийн нөхөн сэргээлт хийх

Уурхайн уулын ажлыг 2 дугаар сараас эхэлж хөрс хуулалт 58.1 мян/м<sup>3</sup> шимт хөрсийг гадаад овоолгод хадгалж, үлдсэн хөрсийг дотоод овоолгод техникийн нөхөн сэргээлтэнд ашигласан. Дотоод овоолгод бутлуур, шигшүүрээс гарсан хаягдал хөрстэй нийлсэн 115,5 мян/м<sup>3</sup> хөрсөөр 0,5 га-д техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэв. (Хавсралт 3. Нөхөн сэргээлт хүлээлгэн өгсөн акт, мэдээг [ЭНД](#) харна уу)



Зураг 18. 0.5 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн байдал

## 5.2 Биологийн нөхөн сэргээлт хийх

Техникийн нөхөн сэргээлт хийсэн дотоод овоолгын 0.3 га талбайд биологийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэв. Тус талбайд говийн нөхцөлд ургах чадвар өндөртэй согоовор, ерхөг, өлөнгө зэрэг олон наст ургамлын үрийг тарьсан.




Зураг 19. Биологийн нөхөн сэргээлт хийж буй байдал

## 6. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	Дэлгэрхангай сумын төвийн цэцэрлэгт хүрээлэнд мот тарих	Орон нутгийн саналын дагуу	Дэлгэрхангай сумын ЗДТГазраас ирүүлсэн саналын дагуу цэцэрлэгт хүрээлэнд мод тарих ажлыг хийж гүйцэтгэсэн.	3,156,399.0	Тухайн жилдээ
<b>Нийт зардал мян. төг</b>				<b>3,156,399.0</b>	

Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд 2022 онд Дэлгэрхангай сумын ЗДТГазраас ирүүлсэн саналын дагуу сумын төвийн цэцэрлэгт хүрээлэнд 5-р сарын 13-наас 17 ний хооронд говийн нэн ховор Жиг мод 300 ширхэг, хайлаас мод 200 ширхэгийг траьж, усалгаа арчилгааг хариуцан хийж гүйцэтгэсэн. (Хавсралт 4. Дүйцүүлэн хамгаалах ажлыг хүлээлгэн өгсөн акт [ЭНД](#) харна уу )

**Байршил:** Дундговь аймаг Дэлгэрхангай сум 45°14'29"N, 104°48'20"E



Зураг 20. Мод тарих нүх ухаж хөрс боловсруулалтын ажил хийж буй байдал



Зураг 21. Жигд, Хайлаас модыг тарьж буй байдал

## 7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Ширээгийн хөндий” гөлтгөний уулын хэсгийн MV-016898 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд малчин өрхийн өвөлжөө, суурин байхгүй хэдий ч манай тусгай зөвшөөрөлтэй хил залгаа үйл ажиллгаа явуулдаг “Эрдэнэгипс” ХХК-ийн хайгуулын талбай дээр байршилтай /манай лицензийн баруун хойд хилээс 500 метр зайд орших/ иргэн Мөнхжаргалын хүсэлтийг үндэслэн 2020 онд 15,045,361.0 төгрөгний зардлаар цахилгааны шугам татаж холбож өгсөн бөгөөд одоогоор нүүлгэн шилжүүлэх өөр айл өрх байхгүй тул энэ онд дээрх үйл ажиллагаатай холбоотой ажил уг төлөвлөгөөнд тусгагдаагүй болно.

## 8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Олборлолт явагдах Ширээгийн гэлтгөний ордын MV-16898 ашиглалтын лицензтэй талбайд түүх, соёлын дурсгалт зүйлс байхгүй, харин талбайгаас зүүн зүгт 4 км зайд сумын хүн хөдөөлүүлдэг газар, баруун хойш 6,4 км зайд эртний хийд бий.

Гэлтгөний орд газрын орчимд байрших түүх соёлын дурсгалт газруудын мэдээллийг дараах хүснэгт үзүүлэв.

Хүснэгт 11.Түүх соёлын дурсгалт газар

№	Аймаг	Сум	Түүх соёлын дурсгалт газар, байгалийн үзэсгэлэнт газрын нэр	Зүг чиг (орд газраас)	Зай км
<b>Агуй</b>					
1	Дундговь	Дэлгэрхангай	Гоожронхой	Зүүн	60.0
<b>Эртний хийд</b>					
2	Дундговь	Дэлгэрхангай	Хошуу хийд	Баруун хойд	6.4
<b>Эртний хот балгасын туурь</b>					
3	Дундговь	Сайхан-Овоо	Цагаан овоо	Баруун	35
<b>Хүн тавьдаг газар</b>					
4	Дундговь	Дэлгэрхангай	Хар чулуун	Зүүн	4

Төсөл хэрэгжүүлэх нутаг дэвсгэрт эртний түүхийн гэрч болох дурсгалт хөшөө бунхан, хиргэсүүр, археологи, палеонтологийн олдворын хайгуул судалгааны ажлыг ШУА-н Археологи, Палеонтологийн төвөөр хийлгүүлсэн ба тус хайгуулын ажлаар ямар нэгэн олдвор илрээгүй болно.

Шинжлэх ухааны академийн түүх, археологийн хүрээлэнгээр Гэлтгөний уурхайн хотхоны 4.2 га, хөрсний овоолгын шигшүүр, бутлуурын 4 га, 3.4 километр үргэлжлэх цахилгаан дамжуулах шугамын трасс, шатахуун түгээх станцын 1.5 га, “Зүүн хэсэг” нэртэй MV-015353 дугаарын ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй 59.11 га талбайнуудад 2019 оны 8-р сарын 16-ны өдөр тус хүрээлэнгийн Угсаатны зүйн судалгааны салбарын эрдэм шинжилгээний ажилтан Э.Дагвадорж угсаатны зүйн авран хамгаалах судалгааг хийж гүйцэтгэв.

Уурхайн үйл ажиллагааны явцад санамсаргүйгээр археологи ба палеонтологийн олдворууд олдох магадлалтай бөгөөд санамсаргүй олдворууд олдсон тохиолдолд Монгол улсын соёлын өвийг хамгаалах хууль болон компанийн “Санамсаргүй олдворын үед ажиллах журам”-ыг дагаж мөрдөж ажиллах болно.

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	Олдвор илэрвэл мэдэгдэх	Гэлтгөний уурхайн ажилчид	2022 оны 10-р сарын 30-ны байдлаар төслийн талбайд олдвор илрээгүй байна.	-	Жилийн турш
<b>Нийт зардал мян.төг</b>				-	

## 9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	Осол эрсдэлийн тухай нийт ажилчдад сургалт явуулах	Нийт ажилтан	Осол эрсдэлийн тухай нийт ажилчдад сургалт оров.	80,0	Тухай бүрт
2	Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн анхан, давтан зааварчилгааг мөрдүүлж ажиллах	Нийт ажилтан	Гөлтгөний нийт ажилчдад анхан болон давтан зааварчилгааг өгсөн.	Үйл ажиллагааны зардал	Тухай бүрд
3	Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, байгаль орчны хяналт мониторинг хийх	Уурхайн хэмжээнд	Мак Цемент ХХК-ийн дотоод хяналт, шалгалтын журамын дагуу хяналт мониторинг хийсэн.	80,0	Ш улиралд зун
4	Төслийн талбайд гал түймрээс сэргийлэх, эрсдлийг бууруулах боломжтой арга хэмжээг авах	Уурхайн талбай дахь бүх барилга байгууламж	Төслийн талбайд гал түймрээс сэргийлэх зорилгоор галын хорыг шаардлагатай газруудад байршуулсан.	Үйл ажиллагааны зардал	Жилдээ
5	ШТС-ын сав, тоног төхөөрөмж, шугам хоолойн битүүмжлэлд хяналт тавих		Ажлын байрны үзлэгийн хуваарийн дагуу ШТС-ын сав, тоног төхөөрөмжийг тогтмол шалгадаг.	Үйл ажиллагааны зардал	Жилдээ
<b>Нийт зардал мян.төг</b>				<b>160.0</b>	

### 9.1 Осол эрсдэлийн тухай нийт ажилчдад сургалт явуулах

Газар хөдлөлт, байгалийн гамшигт үзэгдэл, олныг хамарсан үйлдвэрлэлийн осол гарах үед ажилчдыг аюулгүй байршилд очих буюу цугларах цэгт цуглуулах, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, аврах эрэн хайх бүлэгт ослын мэдээллийг үнэн зөв өгөх зорилготойгоор 2022 оны 07 сарын 15-нд нийт ажилчдад сургалт өгч зохион байгуулагдав.




Зураг 22. Галын сургалт хийж буй байдал

## 9.2 Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн анхан, давтан зааварчилгааг мөрдүүлж ажиллах

МАК Цемент ХХК нь 2022 онд ISO 45001:2015 ХЭМАБ-ийн олон улсын стандартыг нэвтэрүүлэхээр ажиллаж байна. Уг ажлын хүрээнд нийт ажилчдад ХЭМАББО-н сургалт, зааварчилгыг орж ажилласан.

График 3. 2022 оны сургалтын дүн



Графикаас харахад тайлант онд нийт шинэ ажилтны сургалтанд 19 хүнд, ээлжит давтан зааварчилгаанд 95 хүнд, ээлжит бус давтан зааварчилгаанд 120 хүн хамрагдан сургалт зааварчилгааг авсан байна.

## 9.3 Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, байгаль орчны хяналт мониторинг хийх

МАК Цемент ХХК-ийн гүйцэтгэх захирлаар батлагдсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн, дотоод хяналт шалтгалтын журмын дагуу Ширээгийн хөндийн гөлтгөний уурхайд хуваарийн дагуу шалгалтыг явуулсан. Шалгалтыг Мэргэжлийн хяналтын №2.23. “Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хяналтын хуудас”, Байгаль орчны чиглэлээр хяналт мониторинг хийв. Шалгалтаар шланк задарж ус алдах эрсдэл гарсан ба хариуцан ажилтанд заавар зөвөлгөө өгч ажилласан. Мөн ШТС орчим галын аюултай тэмдэг тэмдэглэгээ байршуулаагүй үл тохирол илэрсэн бөгөөд арилгуулах арга хэмжээ авахуулсан. (Хавсралт 5. ХАБЭАБО-н дотоод хаяналт шалгалтын журам, хуваарийг [ЭНД харна уу](#))



Зураг 23. Хяналт шалгалт хийж буй байдал

#### 9.4 Төслийн талбайд гал түймрээс сэргийлэх, эрсдлийг бууруулах боломжтой арга хэмжээг авах

МАК Евро цементийн үйлдвэрээс Гэлтгөний уурхайд шаардагдах галын багаж хэрэгсэл болон галын хорыг үзлэг шалгалт хийн явуулан шаардлагатай газруудад шинээр 30 ширхэг галын хорыг байрлуулсан.



Зураг 24. Үйлдвэрээс ирсэн галын хор суурилуулсан байдал

#### 9.5 ШТС-ын сав, тоног төхөөрөмж, шугам хоолойн битүүмжлэлд хяналт тавих

МАК Цемент ХХК-ийн гүйцэтгэх захирлаар батлагдсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн, дотоод хяналт шалгалтын журмын дагуу ШТС-ын орчимд хуваарийн дагуу шалгалтыг явуулсан.



Зураг 25. Гэлтгөний уурхайн шатахуун түгээх станц



### 10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	Хог хаягдлын цэгт, ариутгал, халдваргүйжүүлэлт хийх	Хог хаягдлын цэгт	Ажилчдын хотхоны хог хаягдал түр хадгалах цэг, түүний орчмын газрыг 2021.07.21-ны өдөр Жавелионы бодисоор ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэв.	250,0	VII
2	Хуванцарын хог хаягдлыг ангилан ялгах	Уурхайн хэмжээнд	Ажилчдын хотхоны хог хаягдал түр хадгалах цэгийг сайжруулж хог хийсч тархах, хөрсөнд бохирдол үүсгэхээс хамгаалах, ангилан ялгалтыг сайжруулж хашаа хамгаалалт, өнгөний кодчилал хаяг бүхий хогийн савнуудыг шаардлагатай цэгүүдэд байршуулсан.	100,0	Жилдээ
3	Зам талбайд хийсч тарсан хог хаягдлын цэвэрлэгээ зохион байгуулах		Хог хаягдлын цэвэрлэгээний хуваарь гарган цэвэрлэгээг хийв.	100,0	Жилдээ
4	Дахин ашиглагдах хаягдлыг 2догч түүхий эд авдаг аж ахуйн нэгж байгууллагад нийлүүлэх. /хуванцар сав, мод, төмөр/		Хуванцар савыг үйлдвэрийн нэгдсэн хогийн цэгт хүргэж ЭКО говь ХХК д хүлээлгэн өгсөн.	250,0	Жилдээ
5	Хог хаягдлын чиглэлээр ажилчдад сургалт орох		5 сарын хугацаанд нийт ажилчидад хог хаягдлын сургалтыг орсон.	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ
6	Хаягдал тосыг цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх		Машин техникийн тос тосолгооны материалын хаягдал тосыг Мак Цемент ХХК-ийн хаягдал тос цуглуулах нөөцлүүрт нийлүүлдэг бөгөөд хаягдал тосыг түр хадгалахдаа хатуу хучилт бүхий талбай дээр байрлуулсан поошгинд цуглуулж байна.	1,500,000	Жилдээ
<b>Нийт зардал мян.төг</b>				<b>2,200.0</b>	

### 10.1 Хог хаягдлын цэгт, ариутгал, халдваргүйжүүлэлт хийх

Гөлтгөний уурхайн ажилчдын хотхон, засвар үйлчилгээний талбай, хог хаягдал түр хадгалах цэг түүний ойр орчмын газрыг 2022.04.25-ны өдөр Сан хими ХХК мэргэжилийн байгууллагаар ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэв.



Зураг 26. Ариутгал, халдваргүйжүүлэлт хийж буй байдал

### 10.2 Хуванцарын хог хаягдлыг ангилан ялгах

Ажилчдын хотхоны хог хаягдал түр хадгалах цэгийг сайжруулж хог хийсч тархах, хөрсөнд бохирдол үүсгэхээс хамгаалах, ангилан ялгалтыг сайжруулж хашаа хамгаалалт, өнгөний кодчилол хаяг бүхий хогийн савнуудыг шаардлагатай 3 цэгүүдэд байршуулсан. (Хавсралт 6. Хог хаягдлын бүртгэлийг [ЭНД](#) харна уу)



Зураг 27. Хогийн цэгийн сайжруулалт



Зураг 28. Ажилчдын хотхон, Засвар үйлчилгээний төвийн ангилан ялгалт



Зураг 29. Хуванцар савыг ангиан ялгаж буй байдал

### 10.3 Зам талбайд хийсч тарсан хог хаягдлын цэвэрлэгээ зохион байгуулах

Уурхайн ажиллаж эхэлсэн 2-р сараас хойш бүх нийтийн цэвэрлэгээг хуваарийн дагуу I, II, III-р улиралд зохион байгуулсан ба нийт 10 ажилтан оролцож, Уурхайн карьер, засварын төв, ажилчдын хотхон ба тээврийн зам дагуу талбайнуудад цэвэрлэгээ хийв. (Хавсралт 7. Хог хаягдлын цэвэрлэгээний хуваарь [ЭНД](#) харна уу.)



Зураг 30. Төслийн талбайд цэвэрлэгээ хийж буй байдал

#### 10.4. Дахин ашиглагдах хаягдлыг 2догч түүхий эд авдаг аж ахуйн нэгж байгууллагад нийлүүлэх

Уурхайгаас цугларсан нийт 200 кг дахивар хаягдал болох хуванцар хаягдлыг Эко говь ХХК-д 2022 оны 07 сарын 24-нд нийлүүлэн хүлээлгэн өгсөн. Эко говь ХХК нь Дорноговь аймгийн Сайншанд суманд дахивар хаягдал бэлтгэн нийлүүлэх үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм. (Хавсралт 8. Эко говь ХХК-д хүлээлгэн өгсөн бүртгэлийг [ЭНД](#) харна уу)



Зураг 31. Дахин боловсруулах үйлдвэрт хүлээлгэн өгч буй байдал

#### 10.5 Хог хаягдлын чиглэлээр ажилчдад сургалт орох

Уурхайн ажилчдад 2022 оны байгаль орчны сургалтын төлөвлөгөө, хуваарийн дагуу 2, 4 саруудад сургалтыг орсон. Сургалтын агуулгад хог хаягдлын ангилан ялгалт, шатах тослох материал, хөрсний бохирдол, унд ахуйн усны хэрэглээ, агаарын бохирдол зэрэг орно. Мөн уурхайн ажилчдад ХАБЭА-н давтан зааварчилгаатай хамтатган байгаль орчны ерөнхий зааварчилгааг улиралд 1 удаа өгч зохион байгуулсан. (Хавсралт 9 .2022 оны сургалтын төлөвлөгөөг [ЭНД](#) харна уу)



Зураг 32. Сургалт, зааварчилгаа орж буй байдал

### 10.6 Хаягдал тосыг цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх

Машин техникийн тос тосолгооны материалын хаягдал тосыг Мак Цемент ХХК-ийн хаягдал тос цуглуулах нөөцлүүрт нийлүүлдэг бөгөөд Цемент шохойн үйлдвэр нь хаягдал тосыг цуглуулж тайланд онд “Монпити ойл” ХХК-ийн дахивар боловсруулах үйлдвэрт нийлүүлэв.

(Хавсралт 10. “Монпити ойл” ХХК-д хаягдал тос хүлээлгэн өгсөн актыг [ЭНД](#) харна уу)



Зураг 33. Хаягдал тос цуглуулах сав болон хаягдал тос өгч буй байдал

### 10.7 Агаарын шүүгч, тосны шүүрийг ангилан ялгах

Уурхайн засварын төвийн үйл ажиллагаанаас гардаг хаягдал болох агаар шүүгч, тосны шүүрийг ангилан ялгаж, агаар шүүгчний гаднах төмрөн торыг дахин ашиглан уурхайн ногоон байгууламж дахь модыг туулай болон мэрэгч амьтдаас хамгаалах 3 ширхэг тор хийж байрлуулсан. Мөн тосны шүүрийн үлдэгдэл тосыг шүүж цэвэрлэн уг хаягдлыг дахин ашиглан уурхайн замын шон хийхэд ашигласан ба тайлант онд нийт 5 ширхэг аюулгүйн шон хийж шаардлагатай газруудад байрлуулсан.



Зураг 34. Агаар шүүгчний тор, тосны шүүрийг дахин ашиглаж буй байдал

## 11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ
